



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/34

Даланзадгад сум

Төлөвлөгөө батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн яамны 2025 оны 04 дүгээр сарын 14-ийн өдрийн 2/1805 дугаартай албан бичгийн дагуу хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж, биелэлтийг хангаж ажиллахыг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтэс (Б.Ганшагай), Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Б.Цагаанцэнд), Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс (Б.Батболд), Хяналт шалгалтын хэлтэс (Б.Оюунсүрэн), Нийгмийн эрүүл мэндийн төв (Б.Амгалан) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэж, хяналт хийж 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдөр тайлагнахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Б.Цагаанцэнд)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ЖАВЗАНДУЛАМ

462501214

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн
А/34 дугаар тушаалын хавсралт


**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНААС ЗОХИОН БАЙГУУЛСАН ШАЛГАЛТЫН МӨРӨӨР
АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Арга хэмжээ	Хариуцах эзэн	Хугацаа
Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр			
1	Аймгийн хэмжээнд ажиллах Мэргэжлийн салбар зөвлөлүүдийг шинэчлэн байгуулж, ажиллах журам, эрх үүргийг тодорхой болгох, салбар зөвлөлийн багийн хурлыг зохион байгуулж үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулах	УТСХ-ийн дарга Б.Ганшагай, ЭТҮХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батболд	VI, VII, VIII-сар
2	Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамж, зааврыг мөрдүүлэх дэмжлэг хяналт хийх /Ханхонгор, Ханбогд, Ноён, Номгон, Манлай Сэврэй, Цогт-Овоо, Ар-Үр сувилал, Өнө-Орших ӨЭМТ, Тэгш дүүрэн, Маналговь эмнэлэг, Итгэлтэй амьдрал ОНӨААТҮГ/	ЭТҮХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батболд	
3	ЭМС-ын 2022 оны А/210 дугаар тушаалыг үндэслэн аймгийн хэмжээнд Ерөнхий мэргэжилтнүүдийг томилох, үйл ажиллагааг идэвхтэй байхад хяналт тавьж хамтран ажиллаж зохион байгуулсан арга хэмжээг тухай бүр танилцуулж байх.	ЭТҮХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батболд,	II, III -р улирал
4	Зөвлөх эмч, мэргэжилтнүүдийн хамтарсан тойрон үзлэг, “Зөвлөн туслах”, “Ажлын байрны дадлага сургалт”, “Гардан үйлдлийн сургалт” арга хэмжээг төлөвлөн тодорхой давтамжтайгаар арга хэмжээг зохион байгуулах 3 жилийн төлөвлөгөө гаргаж танилцуулах сургалтад хамрагдах эмч мэргэжилтний судалгааг гаргах, сургалтын үр дүнг тооцож ажиллах.	УТСХ-ийн дарга Б.Ганшагай, ЭТҮХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батболд	II, III -р улирал
5	Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, жирэмсэн, эх хүүхдэд үзүүлж буй тусламж үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн эх барихын ноцтой хүндрэлийн шалтгаан нөхцөл, бага жинтэй төрсөн нярай, хэт бага жинтэй амьд нярай, дутуу төрөлт, амьгүй төрөлт, гэрийн төрөлт, перинатал болон нярайн эндэгдлийн тохиолдол бүрд жирэмсний хяналт, гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээнд тандалт судалгаа хийж, эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил	ЭТҮХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батболд,	II, III -р улирал

	арга зүйгээр хангах, шаардлагатай асуудлыг орон нутгийн удирдлагатай хамтран шийдвэрлэж ажиллах төлөвлөгөө гарган ажиллах		
6	Эрүүл мэндийн байгууллагуудын шатлал, тусламж үйлчилгээний онцлогт төрөлжсөн сувилахуй, сувилахуйн тусламж үйлчилгээтэй холбоотой 5 шатлалыг хэрэгжүүлэхэд: - Түгээмэл зонхилон тохиолдож буй үнэлгээ - Онош тавилт - Хэрэгжүүлэхэд чиглэгдсэн төлөвлөгөө - Үр дүн, дүгнэлтийг гаргах талаар аргачлал боловсруулан мэргэжил арга зүйгээр хангах	ЭТҮХ-ийн сувилахуйн тусламж үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн А.Мөнхтуяа	II, III -р улирал
7	ЭМС-ын 536 тушаалын 1.5.3 заасан чиглэлийн хүрээнд Халдварын сэргийлэлт, хяналтыг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий аймгийн салбар зөвлөлийг шинээр байгуулах, төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллах, ЭМБ-уудын халдварын сэргийлэлт хяналтыг багыг чадавхжуулах, арга зүйгээр хангах	НЭМТ-ийн дарга Б.Амгалан ХШХ-ийн дарга Б.Оюунсүрэн	II, III -р улирал
8	Шим билэг өрхийн эрүүл мэндийн төв дотор үйл ажиллагаа явуулж буй эмийн сангийн орц, гарцыг эмнэлгийн хаалганаас тусдаа болгох, эмийн санг эмнэлгийн байрнаас гаргах асуудалд дэмжлэг үзүүлж шийдвэрлэх цаашид тусгай зөвшөөрөл олгоход анхаарч ажиллах.	ХШХ-ийн дарга Б.Оюунсүрэн ЭТҮХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батболд	II, III -р улирал
9	Хэвтэн эмчлүүлэх ор бүхий эмнэлгүүдийн тогооч нарыг эмнэлзүйн хоолны тогооч нарыг мэргэшүүлэх, арга зүйгээр бодлогын хэмжээнд арга хэмжээ зохион байгуулах	НЭМТ-ийн дарга Б.Амгалан	III -р улирал
10	Эмнэлгүүд “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартад заасан гадна, дотор талын хаягжилт, орц гарцын тэмдэглэгээ тодорхойгүй хэвээр, үзүүлж буй тусламж үйлчилгээ, ажлын байрны онцлогоос хамааран хувцаслалтын ялгаатай байдлыг зохицуулаагүй зэрэг үйлчилгээний стандарт хангагдаагүй тул бүрэн хангуулахад анхаарч ажиллах, хяналт тавих	ЭТҮХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Батболд	II, III -р улирал
11	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2023, 2024 оны эм, эмнэлгийн хэрэгслийн өрийн асуудлыг бодлогын түвшинд яаралтай шийдвэрлэхэд зохицуулалт хийх, эм, эмнэлгийн хэрэгсэлийн тасалдал үүсгэхгүй, эмчилгээ үйлчилгээнд эрсдэл үүсэх зэргээс урьдчилан сэргийлж мэргэжил аргазүйн чиглэлээр хамтран ажиллах, өрийн асуудлыг шийдвэрлэсэн талаар санал хүргүүлэх, арга зүйгээр хангах.	УТСХ-ийн дарга Б.Ганшагай, ЭТҮХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батболд	II, III -р улирал
9	Сум өрхийн эрүүл мэндийн төвүүд нутаг дэвсгэрийн хүн амыг эрүүл мэндийн 5, айл өрхийг эрсдэлийн 3 бүлгээр тус тус ангилан, хяналт тогтоож, эрэлт хэрэгцээнд тохирсон тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч хяналт тавьж ажиллах	ЭТҮХ-ийн УАУ, СЗ-ын тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн М.Цэцэгсүрэн	VI, VII, VIII-сар

10	Эмнэлгийн захиргаанаас өвчтөнд үзлэг хийх, үйлчлүүлэгчийг хүлээлцэх, тасаг хооронд өвчтөн шилжүүлэх, эмч дуудах, эмч нарын хамтарсан үзлэг зохион байгуулах, өвчний түүх хөтлөлтийн талаар тодорхой гаргасан журмын төслийг боловсруулан хэлэлцэж ЭМБ-уудад танилцуулж журмын хэрэгжилтийг хангуулах	ЭТҮХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батболд	VI, VII, VIII-сар
Боловсролын байгууллагын түвшинд			
	Сургууль цэцэрлэгийн эмч, тогооч нарыг чадавхжуулах, арга зүйгээр хангах,	НЭМТ-ийн дарга Б.Амгалан ХШХ-ийн дарга Б.Оюунсүрэн	II, III -р улирал
	Боловсролын байгууллагын барилга байгууламжийг шинээр барих, ашиглалтад оруулах, өргөтгөл хийхэд урьдчилсан хяналтыг чанартай хийх	ХШХ-ийн дарга Б.Оюунсүрэн	II, III -р улирал
	Сургалтын байгууллагын хүнсний түүхий эд бүтээгдэхүүнээр хангагч ААНБ-дад Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх	НЭМТ-ийн дарга Б.Амгалан ХШХ-ийн дарга Б.Оюунсүрэн	II, III -р улирал
Хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд			
	Хяналт шалгалт хийхэд шаардлагатай багаж хэрэгсэл, хурдавчилсан тест зэргийн судалгааг гаргаж, шийдвэрлүүлэх	ХШХ-ийн дарга Б.Оюунсүрэн	II, III, IV-р улирал
	Улсын байцгаагчдыг орон тоогоор ажиллуулах, хүний нөөцийг бүрдүүлэх	ТЗУХ-ийн дарга Б.Ганшагай ХШХ-ийн дарга Б.Оюунсүрэн	II, III -р улирал
	Салбарын хяналтын хяналт шалгалтад хамрагдаагүй объектыг эрсдэлийн үнэлгээнд бүрэн хамруулах, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах	ХШХ-ийн дарга Б.Оюунсүрэн	II, IV-р улирал
	Төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан байгууллагуудад гүйцэтгэлтийн хяналтыг зохион байгуулах	ХШХ-ийн дарга Б.Оюунсүрэн	III, IV-р улирал
	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, нэгтгэх, тайлагнах	ХШҮМХ-ийн дарга Б.Цагаанцэнд	VIII-сарын 20

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ МЭДЭЭЛЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА  Б.ЦАГААНЦЭНД